



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/М/4

Улаанбаатар хот


□ 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд цалинтай
чөлөө олгох тухай □

Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны “Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол улсад шинэ төрлийн коронавирус /Ковид-19/-ийн халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан тус өвчний тархалтыг саармагжуулж, урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдүүдийг харгалзах хүнтэй байлгах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд цалинтай чөлөө олгож, гэрээс нь ажиллуулсугай.
2. 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Энэ зохицуулалтад хамаарах ажилтнууд дуудсан цагт бэлэн байж, холбоо барих утсаа нээлттэй байлган гэрээсээ албан үүргээ гүйцэтгэх хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг Ахлах мэргэжилтэн /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.
4. Дээрх ажилтнуудын цалин хөлсийг бүтэн цагаар ажилласнаар тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

С.БАТЖАРГАЛ



Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨААТҮГ-аар даргын
2019 оны 03 сарын 17-ны өдрийн 1114 тоот
тушаалын хавсралт



НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГАЗРЫН 0-12 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭХЧҮҮДИЙН НЭРС

Д/д	Ажилтны нэр	Амралтын хоног	0-12 насны хүүхдийн тоо
1	Ц.Бямбасүрэн	Ахлах нягтлан бодогч	1
2	Э.Ундармаа	Нярав	1
3	Э.Энгүүн	Маркетинг ОНХХ хариуцсан мэргэжилтэн	2
4	Х.Бямбаа	Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	2
5	О.Чулуун-Эрдэнэ	Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1